МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Зөв зүгт
манлайлна

2021 ENTREPRENEUR
САЙН ЗАСАГЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ЭНТРЕПРЕНЁР



Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025.09-Р САР

МБҮА

+976-7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци

РЕДАКЦИ

ХЯНАН ТОХИОСОН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.БАТСҮХ

НЭГТЭЛ РЕДАКТОР:
Б.ТӨВШИНБОЛОР

ОРОЛЦСОН:
АЖЛЫН АЛБА

АГУУЛГА

НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

- ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ, САЛБАРЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, НОРМ, ДҮРЭМ ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР
- ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР
- ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛЭХ

НИЙГМИЙН ҮНЭ ЦЭНИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

- ХОТ СУУРИН ГАЗАР, ДАГУУЛ ХОТУУДЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД
- ДЭД БҮТЭЦ, ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД

ГИШҮҮНЧЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

- УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
- ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО, ГРАФИК, ҮЗҮҮЛЭЛТ
- ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДАА САЛБАРЫН БОДЛОГО, СУДАЛГААГААР ХАНГАЖ АЖИЛЛАЖ БАЙГАА БАЙДАЛ
- ГИШҮҮДИЙГ СУРГАЛТ, ТУРШЛАГА СУДЛУУЛАХ АЯЛАЛ, ВОРКШОП АРГА ХЭМЖЭЭНД ХАМРУУЛСАН БАЙДАЛ
- ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН НИЙТ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛЭЭР СУРТАЛЧИЛСАН НЬ

МБҮА

SINCE 2009

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

Зөв зүгт Манлайлна



МБҮА

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

SINCE 2009

Зөв зүгт Манлайлна

21 АЙМАГТ АССОЦИАЦИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙГ байгуулж эхэллээ

АССОЦИАЦИ НЬ САЛБАР ЗӨВЛӨЛҮҮДТЭЙ ДАРААХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАНА.

- Сургалт, зөвлөгөөн
- Туршлага солилцоо
- Төслүүд, хөрөнгө оруулалт
- Шударга өрсөлдөөн, стандартын хяналт

7011 1515 info@mnca.mn

www.mnca.mn



БАЯН-ӨЛГИЙ **ХОВД** **ДАРХАН-УУЛ**

Аймгуудад САЛБАР ЗӨВЛӨЛ-ийг байгуулаад байна.

Үндэсний үйл ажиллагааны зорилтын хүрээнд



www.mnca.mn

Монгол Улс, БНХАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж байгаа энэ үед хоёр орны бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой Монгол, Хятадын “БАРИЛГА, ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ФОРУМ-2025”-ыг 2025.09.18-20-ны хооронд зохион байгууллаа.

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь БНХАУ-ын Олон улсын гэрээлэгчдийн нийгэмлэг (CHINCA)-тай албан ёсны хамтын ажиллагаагаа эхлүүлж “САНАМЖ БИЧИГ” зурснаар жил бүр CHINCA&MNCA форум, үзэсгэлэнг аль нэг улсад ээлжлэн зохион байгуулах, барилга байгууламжийн хууль, дүрэм, техникийн стандарт, салбарын хөгжилтэй холбоотой мэдээлэл солилцох, Гишүүн компаниудаа хооронд нь танилцуулах, бизнес уулзалт, B2B боломжуудын төлөвлөгөөг зохион байгуулж, хэрэгжүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөрүүд боловсруулах, барилгын төслүүдэд хөрөнгө оруулалт, санхүүжилт татах чиглүүдэд хамтран ажиллахаар тогтлоо.

Форумын арга хэмжээг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд нээж үг хэлсэн бол БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Шэнь Миньжуань хоёр улсын хамтын ажиллагаа батжин бэхжиж байгаад талархал илэрхийлэн харилцаа хамтын ажиллагааны шинэ шат ахиж байгаа онцлон тэмдэглэлээ.

Уг арга хэмжээг хүндэтгэн Монгол Улсын томоохон бүтээн байгуулалтад оруулж буй хувь нэмэр, хамтарсан төслүүдийн үр дүн амжилттай явагдаж байгааг Монгол Улсаас БНХАУ-д суугаа Онц бөгөөд бүрэн эрхэт Элчин сайд Н.Энхболд мэндчилгээ илгээсэн бол МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, БНХАУ-ын Олон Улсын Гэрээлэгчдийн Нийгэмлэгийн Ерөнхийлөгч Фан Чючэн нар хамтын ажиллагааны ололтыг шинэ шатанд гаргасанд таатай байгаагаа илэрхийллээ.





Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ МБҮА ТББ нь БНХАУ-ын Олон улсын гэрээлэгчдийн нийгэмлэг (CHINCA)-тай 2017 оноос хойш ойр дотно, үр өгөөжтэй хамтын ажиллагааг тууштай өрнүүлж ирсэн билээ. Сүүлийн жилүүдэд МБҮА ТББ нь БНХАУ-ын Засгийн газар болон CHINCA-гаас хамтран зохион байгуулдаг “Олон улсын дэд бүтцийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын дээд хэмжээний форум” (Макао)-болдог арга хэмжээнд тогтмол оролцож, харилцан ойлголцол, туршлага солилцоогоо гүнзгийрүүлсний үр дүнд 2025.09.18-ны өдөр Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ МБҮА ТББ нь БНХАУ-ын Олон улсын гэрээлэгчдийн нийгэмлэг (CHINCA)-тай албан ёсны хамтын ажиллагаагаа эхлүүллээ. Уг САНАМЖ БИЧИГ-т МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, CHINCA-ийн Ерөнхийлөгч Фан Чючен нар гарын үсэг зурж албажуулаа.

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

- ✓ 2025.09-р сард Улаанбаатар хотод CHINCA&MNCA форум, үзэсгэлэнг зохион байгуулах, цаашид жил бүр БНХАУ-ын Бээжин юмуу Улаанбаатар хотод ээлжлэн үзэсгэлэнг зохион байгуулж, хамтран ажиллах
- ✓ Барилга байгууламжийн хууль, дүрэм, техникийн стандарт, салбарын хөгжилтэй холбоотой мэдээлэл солилцох
- ✓ Гишүүн компаниудаа хооронд нь танилцуулах, бизнес уулзалт, B2B боломжуудын төлөвлөгөөг зохион байгуулж, хэрэгжүүлэх
- ✓ Хамтарсан төсөл, хөтөлбөрүүд боловсруулах
- ✓ Барилгын салбарынхыг хамруулсан хууль, дүрмийн сургалт, семинар зохион байгуулах
- ✓ Салбарын их дээд сургууль, сургалтын төвүүдтэй хамтран хөдөлмөрийн сургалт, чиглүүдэд хамтран ажиллахаар тогтлоо.

Ийнхүү энэхүү хамтын ажиллагаа нь дотоодын барилга, дэд бүтцийн компаниудаа олон улсын зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлээд зогсохгүй, гадаадын хөрөнгө оруулалт, дэвшилтэт технологийг нутагшуулах замаар салбарын орчин үеийн хөгжил, чадавхыг дээшлүүлэхэд анхаарч төсөл хэрэгжүүлэгч компаниудын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх шинэ боломжийг нээж өгч байгаа томоохон арга хэмжээ боллоо.


CET 2025


CET 2025
第19届中国工程技术展览会
中国-蒙古国基建投资论坛




CET 2025
第19届中国工程技术展览会
中国-蒙古国基建投资论坛


CET 2025





БАРИЛГЫН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН, ФОРУМЫН АЧ ХОЛБОГДОЛ

Монгол Улсын 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр Дотоодын нийт бүтээгдэхүүн 80.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 13.5 хувиар өссөн нь эдийн засгийн өсөлт тогтвортой үргэлжилж байгааг илтгэж байна. Энэ өсөлтөд барилгын салбар 0.3 нэгж хувийн хувь нэмэр оруулсан бөгөөд салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ 3.3 хувьд хүрсэн нь барилгын салбар нь эдийн засгийн бүтцэд чухал байр суурь эзэлж байгааг; Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хувьд 1990-2024 оны хооронд Монгол Улсад нийт 48.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт орсон бөгөөд үүнээс барилгын салбар 2.0 хувийг эзэлж, ойролцоогоор 1.0 тэрбум ам.долларыг бүрдүүлжээ. 2011-2024 оны хооронд тус салбарын жилийн дундаж урсгал хөрөнгө оруулалт 65.8 сая ам.долларт хүрсэн нь салбарын хөрөнгө оруулалтын орчин тогтвортой, өсөлттэй байгааг;

Хөдөлмөрийн зах зээлийн хувьд 2024 онд барилгын салбарт ажиллагсдын тоо 93,165-д хүрч, өмнөх оноос 13.5 хувиар өссөн нь нийт ажиллагсдын 6.9 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд тус салбарын ажиллагсдын эзлэх хувь нийт ажиллагсдын 5.6–7.7 хувийн хооронд хэлбэлзэж байгаа нь барилгын салбар нь тогтвортой ажлын байр бий болгож, хөдөлмөр эрхлэлтийн чухал салбар байсаар байгааг тус тус илтгэж байна.

ФОРУМД БНХАУ-ЫН ДЭЛХИЙН ШИЛДЭГ 500-Д БАГТДАГ ГАДААДАД ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИД, ГҮЙЦЭТГЭГЧИД, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД ОРОЛЦЛОО

Уг форумд БНХАУ-ын зүгээс Дэлхийн шилдэг 500-д багтдаг Хятадын хөрөнгө оруулагчид, төсөл хэрэгжүүлэгчид болох Shanghai Construction Group, China Railway Signal & Communication Co.,Ltd, China North Industries Corporation, China Machinery Engineering Corporation, Beiben Trucks Group Co.,Ltd, Shaanxi Construction Engineering Corporation гээд 150 гаруй компаниуд өөрсдийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг танилцуулахаас гадна Монгол Улсад өрнөж буй бүтээн байгуулалтын томоохон төслийн мэдээлэлтэй танилцлаа.

Мөн Монгол Улсад өрнөж буй бүтээн байгуулалт, хөрөнгө орчны талаар ХББОСЯ-наас "Монгол Улсын Барилга, барилгын материал дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтын орчин, боломж", Нийслэлийн "24 Мега төсөл"-ийн өнөөгийн байдал, Хүннү хотын захиргаанаас Хүннү хот төсөл, Хөрөнгө оруулалт, худалдааны газраас



"Хөрөнгө оруулалтын орчин ба нөхцөл", БНХАУ-ын Төмөр замын дохиолол, харилцаа холбооны корпорацийн үйлдвэрлэлийн давуу талыг ашиглан Монголын төмөр замын тээврийн шинэ хөгжлийг дэмжих нь, МБҮА ТББ-иас "Монгол Улсын барилгын зах зээлд нэвтрэх боломж, нөхцөл шаардлага" илтгэлүүдийг тавилаа.

Харин дараагийн хэсэгт хувийн хэвшлийн томоохон төлөөллүүд болох Номин констракшн деволмент групп ХХК "NCD Group-Хөрөнгө оруулалтын төслүүд", Гурван бухат групп "Арга билиг", Барилгачин групп "Монгол Хятадын барилгын материалын худалдааны гүүр", Ай Ди Си Ай групп "Улаанбаатар хотод хүн төвт амьдралын шинэ эринийг цогцлоохуй" зэрэг томоохон төслүүдийг хөрөнгө оруулагчдад танилцуулж, мэдээлэл солилцлоо.


Форумын хүрээнд зохион байгуулагдсан цуврал арга хэмжээний хүндэтгэлийн хүлээн авалтыг МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, БНХАУ-ын Олон Улсын Гэрээлэгчдийн Нийгэмлэгийн Ерөнхийлөгч Фан Чючэн нар нээсэн бөгөөд хоёр улсын хүндэт зочдод Монголын Үндэсний урлагийн үзвэрүүдээс толилууллаа. Мөн дараагийн өдөр Монгол Улсад хүрэлцэн ирсэн CHINCA-ийн зочид төлөөлөгчдийг ЧИНГИС ХААНЫ музейгээр зочлуулж их хааны хөрөг сэнтий, түүх дурсгалтай танилцууллаа.

ДҮГНЭЛТ, ҮР НӨЛӨӨ:

МБҮА ТББ нь 2010 оноос хойш БНХАУ-ын Олон Улсын Гэрээлэгчдийн Нийгэмлэг (CHINCA)-тай харилцаа тогтоож өнөөдрийг хүртэл хоёр улсын хувийн хэвшлийн барилгын аж ахуйн нэгжүүдийг холбох, хамтын ажиллагааг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд жил бүр тус байгууллагаас зохион байгуулалдаг “ОЛОН УЛСЫН ДЭД БҮТЭЦ, БАРИЛГЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ” форумд гишүүн байгууллагуудаа хамруулах, хамгийн сүүлийн үеийн мэдээллийг өгөх чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. гаргахад дэмжлэг үзүүлээд зогсохгүй, гадаадын хөрөнгө оруулалт, дэвшилтэт технологийг нутагшуулах замаар салбарын орчин үеийн хөгжил, чадавхыг дээшлүүлэхэд анхаарч төсөл хэрэгжүүлэгч компаниудын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх шинэ боломжийг нээж өгч байгаа томоохон арга хэмжээ боллоо.



2.НИЙГМИЙН ҮНЭ ЦЭНЭ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



БАРИЛГЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛДААН БОЛЛОО



Монгол Улсын барилгын салбарын хөгжил, шинэчлэлийн стратегид томоохон өөрчлөлт авчирахын тулд салбарын хууль эрх зүйн шинэчлэл, өөрчлөлт ихээхэн хамааралтай бөгөөд Барилгын ерөнхий хууль, Хот байгуулалтын тухай хууль, Орон сууцны ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга,Үндэсний орон сууцжуулалтын тухай зэрэг барилгын салбарын багц хуулийн төслүүдийг боловсруулан батлуулахаар салбарын яам, салбарын ТББ-уудтай хамтран Ажлын хэсэг гарган идэвхтэй ажиллаж байгаа билээ. Тус ажлын хүрээнд Хот байгуулалт, барилга хот байгуулалтын яаманд 2025.09.26-ны өдөр Барилгын Ерөнхий хуулийн Ажлын хэсэг хуралдаж Барилгын Ерөнхий хуулийн төслийг ирэх 10-р сард ХЗДХЯаманд хүргүүлж, 11-р сард Засгийн газарт, 12-р сард УИХ-д өргөн барихаар төлөвлөж ажиллаж байгаа талаар ББМБЗГ-ын дарга Д.Энхбаатар танилцуулга хийж Гишүүдийн саналыг сонслоо.

Иймд тус хуулийн төслийг өргөн барихтай холбогдуулан олон нийтийн саналын хүлээн авч байгаа бөгөөд эрхэм Гишүүд та бүхнийг Барилгын Ерөнхий хуулийн үзэл баримтлалд яаралтай саналаа өгөхийг хүсэж байна.

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ХАМТАРСАН ТҮНШЛЭГЧ МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДЫН ХУРАЛ БОЛЛОО

Монголын Барилгын Үндэсний Ассоцици, Монголын Барилгын Инженерүүдийн Холбоо, Монголын Барилгын Зураг Төсөл Зохиогчдын Холбоо, Монголын Барилгын Төсөвчдийн Холбоо, Монголын Барилгын Инженер Геологичдын Холбоо, Өргөн Тээвэрлэх Машин Техөөрөмж Үндэсний Холбоо, Монголын Барилгын Гүйцэтгэгч Байгууллагуудын Холбоодын Ерөнхийлөгчид, удирдлагууд оролцож, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл болон шинээр нэвтрүүлж байгаа зөвшөөрлийн цахим нэгдсэн систем lisence.mn цахим системтэй танилцаж, цаашдын хамтран зохион байгуулах ажлуудын талаар хэлэлцэж тохирлоо.



Хурлаар Зөвшөөрлийн цахим нэгдсэн систем license.mn-д барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нэгтгэсэнээр аж ахуйн нэгж байгууллагуудын хувьд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа илүү түргэн шуурхай болж шаардлага хангасан бол хүсэлт илгээснээс хойш 5 хоногт тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон гэрээг QR кодтой шууд хүлээн авах боломжтой болох юм.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахад хүндрэлгүй, хялбар шуурхай болж байгаа ч тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын тоо нэмэгдэж, чанаргүй барилга барих, барилгын талбайд ХАБЭА-н хууль дүрэм мөрдөхгүй байх, иргэд захиалагчдыг хохироох зэрэг зөрчил гарсаар байна. Иймд түншлэглэгч ТББ-ууд барилгын чанар аюулгүй байдлыг хангахад түлхүү анхаарч, хамтарсан сургалт арга хэмжээ зохион байгуулах, барилгын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-д тавих хяналтыг нэмэгдүүлж ажиллахаар боллоо.

3.ГИШҮҮНЧЛЭЛ УЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХУРЭЭНД

МБУА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Зөв зүгт Манлайлна



www.mnca.mn

СЭЛБЭ ХОТЫН ОРОН СУУЦЖУУЛАХ 3,4-Р БАГЦЫН ТЕНДЕРТ МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН МОНКОН КОНСТРАКШН ХХК, НУТГИЙН БУЯН ГРУПП ХХК НАР ШАЛГАРЧ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛЛОО

Сэлбэ хотын орон сууцжуулах төслийн 3, 4 дүгээр багц тендерийг задалж, тав хуваан зарласан. Уг тендерт дотоодын 17, гадаадын 17 аж ахуйн нэгж таван багц тендерт давхардсан тоогоор 64 тендерийн санал ирүүлснээс Нутгийн буян групп ХХК, Монкон констракшн ХХК, Професионалстрой ХХК, Моринсувд ХХК, China Construction Fifth Engineering Bureau тендерт шалгарлаа.

Тухайлбал:


•Багц 3.1 буюу Сэлбэ дэд төвийн 71 айлын есөн давхар бүхий 11 блок орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендерт “China Construction Fifth Engineering Bureau” компани,


•Багц 3.2 буюу Сэлбэ дэд төвийн 71 айлын есөн давхар бүхий 12 блок орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендерт “Моринсувд” ХХК,


•Багц 3.3 буюу Сэлбэ дэд төвийн 71 айлын есөн давхар бүхий 14 блок орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендерт “Нутгын буян” ХХК,

•Багц 4.1 буюу Сэлбэ дэд төвийн 71 айлын есөн давхар бүхий 16 блок орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендерт “Монкон констракшн ХХК ”

•Багц 4.2 буюу Сэлбэ дэд төвийн 71 айлын есөн давхар бүхий зургаан блок болон 71 айлын 12 давхар бүхий найман блок орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендерт “Професионалстрой” ХХК шалгарсан юм. Өнгөрсөн хугацаанд МБҮА ТББ нь Нийслэлээс зарласан мега төслүүдэд дотоодын барилгын компаниудыг оролцуулах боломжоор хангахын тулд Нийслэлийн удирдлагууд, төслийн удирдлагын нэгжүүд, холбогдох албаны хүмүүстэй 2024.12-р сараас хойш шат дараалсан уулзалт, хэлэлцүүлэг, Санамж бичиг байгуулах чиглэлээр ажиллаж Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гарган Монополын эсрэг газар албан хүсэлт өгч, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, УИХ-ын дарга








Д.Амарбаясгалан нарт албан шаардлага хүргүүлснээр 2025.06.25 уг тендерийг хуваах шийдвэрийг гаргуулсан билээ. Дээрх арга хэмжээнүүдийн хүрээнд Сэлбэ хотын орон сууцжуулах төслийн 3, 4 дүгээр багц тендерийг задалж, тав хуваан зарласнаар Монгол компаниуд оролцох боломжийг олгуулсан юм.

Монгол компаниудыг уг төсөл хөтөлбөрт хамруулах тал дээр Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, орлогч дарга Т.Даваадалай, Сэлбэ хорин минутын хот ХХК-ийн захирал У.Баатар нар идэвх санаачилга гаргаж тендерийг хуваах шийдвэр гаргаж өгсөнд гүнээ талархал илэрхийлье.

Мөн уг акцад хамтран оролцсон бүх Төрийн бус байгууллагуудын удирдлага, барилгачиддаа талархал илэрхийлье.

БАРИЛГЫН САЛБАРЫН ТҮҮЧЭЭЛЭГЧИД

Монгол Улсын Барилга, хот байгуулалтын салбараас өнгөрсөн 99 жилийн хугацаанд ХӨДӨЛМӨРИЙН БААТАР 13, ГАВЬЯАТ БАРИЛГАЧИН 140 орчим төрснөөс МБҮА ТББ-аас Хөдөлмөрийн баатар, гавьяат барилгачин 1, Гавьяат барилгачин 14, Аж үйлдвэрийн гавьяат 3, Гавьяат тээвэрчин 1 төрсөн байна.

Тухайлбал:

-Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, гавьяат барилгачин Д.Баттөр
-Гавьяат барилгачин Н.Баярсайхан
-Гавьяат барилгачин Б.Нэмэхбаатар
-Гавьяат барилгачин Х.Чинбат
-Гавьяат барилгачин Н.Цогтоо
-Гавьяат барилгачин Б.Болд
-Гавьяат барилгачин Д.Баасансүрэн
-Гавьяат барилгачин Ж.Батсайхан
-Гавьяат барилгачин О.Батсайхан
-Гавьяат барилгачин Д.Баянцагаан
-Гавьяат барилгачин Б.Цогтсэргэлэн
-Гавьяат барилгачин Д.Бат-Орших
-Гавьяат барилгачин М.Хүрэлбаатар
-Гавьяат барилгачин Г.Лосол
-Гавьяат барилгачин Ш.Энхтөр
-Аж Үйлдвэрийн Гавьяат ажилтан Д.Цэрэнжигмэд
-Аж Үйлдвэрийн гавьяат ажилтан Б.Ариунболд
-Аж Үйлдвэрийн гавьяат ажилтан С.Мөнхбат
-Гавьяат тээвэрчин Х.Болдбаатар нар болоод байна.

ХЭНТИЙ АЙМГИЙН БАРИЛГЫН САЛБАР ҮҮСЭН БАЙГУУЛАГДСНЫ ОЙД ТАЛАРХАЛ ХҮРГЭЛЭЭ



Монгол Улсад барилгын салбар үүсэж хөгжсөний 99 жилийн ойг угтаж Эзэн Чингис хааны өлгий нутаг Хан Хэнтий нутгийн Засаг даргын тамгын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Барилгачдын холбооны зүгээс Хэнтий аймагт шинэ үеийн барилгын салбар үүсэж хөгжсөний 65 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүллээ.

Мөн барилга бүтээн байгуулалтын салбарт шинэ техник технологи нэвтрүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах, норм дүрэм стандартыг мөрдүүлэх, Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдээ мэдээлэл, сургалтын чиглэлээр хамтран ажиллахад нээлттэй гэдгээ илэрхийллээ.

“БАРИЛГЫН САЛБАРЫН 99 ЖИЛИЙН ОЙ”-Н БАЯРААР МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУД ШИЛДЭГЭЭР ШАЛГАРАВ



Монгол Улсын “БАРИЛГЫН САЛБАРЫН 99 ЖИЛИЙН ОЙ”-н баяраар:

- ✓ Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны сайд Э.Бат-Амгалан барилгын тусгай зөвшөөрлийн үйл суурь нөхцөл шаардлагаа шинэчлэн хөнгөвчилсний зэрэгцээ цахим программ хангамжаа шинэчлэн аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг тусгай зөвшөөрлийн нэгдсэн сан license.mn -ээр дамжуулан авахад бэлэн болоод байгааг олон нийтэд танилцууллаа. Ингэснээр аж ахуйн нэгж байгууллагуудын хувьд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа илүү түргэн шуурхай болж сайдын

тушаал болон гэрээ байгуулах процессыг цахим болгож байна.

Өнгөрсөн хугацаанд МБҮА ТББ-ын гишүүд барилгын салбарт:
2022 ОН
ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ:
Барилга угсралтын чиглэлээр: Нутгийн буян групп ХХК
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр:
Монкон констракшн ХХК
ШИЛДЭГ БАРИЛГА:
NCD Group-ийн RIVER PLAZA бизнес концепц бүхий худалдаа үйлчилгээ, оффис, орон сууцны цогцолбор
Бодь Пропертийз ХХК-ийн гүйцэтгэсэн Таван толгойн төмөр замын өртөө зогсоолуудын барилга байгууламжуудын цогцолбор
Хурд пропертийз ХХК-ийн хөрөнгө оруулалтаар баригдсан “НИСЭХ ГАРДЕН” орон сууцны хотхон
2023 ОН
Барилга угсралтын чиглэлээр: Монкон констракшн ХХК
Инженерийн шугам сүлжээний чиглэлээр: Макс өргөө ХХК
2024 ОН
Барилга угсралтын чиглэлээр: Макс Өргөө ХХК
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр: НБИК ХХК нар шалгарч байжээ.
2025 ОН



Макс өргөө ХХК, Монкон констаркшн ХХК, N.A.P Group Тэсо ХХК-ийн “Актив гарден” төслүүд шалгарлаа.

МОНГОЛЫН НОГООН БАРИЛГЫН ХҮРЭЭЛЭН ДЭЛХИЙН НОГООН БАРИЛГЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН БОЛЛОО



Монголын Ногоон Барилгын Хүрээлэн Дэлхийн Ногоон Барилгын зөвлөлийн албан ёсны Гишүүн болсон арга хэмжээнд Дэлхийн Ногоон Барилгын зөвлөлийн (World Green Building Council) Европ, Төв Азийн бүсийг хариуцсан Дэд ерөнхийлөгч Ричард Тейхманн, тус хүрээлэнгийн Удирдах зөвлөлийн гишүүд болоод Гишүүн байгууллагуудын төлөөлөл оролцож Дэлхийн Ногоон Барилгын чиг хандлага, хэтийн төлөв, үйл ажиллагаа, зорилго зорилттой танилцлаа. Монголын Ногоон Барилгын Хүрээлэн ТББ нь хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, барилга байгууламжийн ашиглалтын зардлыг бууруулах, ногоон хөрөнгө оруулалтыг татах, иргэдэд ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тасралтгүй сургалт, мэдээллийг өгч ажиллаж байгаа юм. МБҮА нь Монголын Ногоон Барилгын Хүрээлэнгийн гишүүнийн хувьд барилгын салбарт ногоон барилгын бодлогыг хэрэгжүүлэхэд анхааран ажиллаж байгаа бөгөөд агаарын бохирдлыг бууруулах Дулаан шийдэл төслийг 7 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. МНБХ-ийн зүгээс BestGER үндэсний ногоон барилгын үнэлгээний аргачлалыг хөгжүүлсэн ба барилга байгууламжийг Ногоон барилга гэж тодорхойлж, гэрчилгээжүүлэх эрхзүйн орчин, хүний нөөц, талуудын оролцооны талаар идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа билээ. Монголын Ногоон Барилгын Хүрээлэн Дэлхийн Ногоон Барилгын зөвлөлийн албан ёсны Гишүүн болсоноор BestGER ногоон барилгын үнэлгээний системийн Олон улсад хүлээн зөвшөөрөхөд чухал алхам болж, Ази болон Европийн бүсийн орнуудаас мэдлэг туршлага суралцах, өөрсдийн хийж байгаа ажлын үр дүнг Олон улсад таниулах чухал ач холбогдолтой юм.

38 ДАХЬ УДААГАА ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БУЙ "BARILGA EXPO" ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГТ МБҮА ТББ-ИЙН ГИШҮҮН 40 ОРЧИМ ААНБ ОРОЛЦЛОО



Барилгын материал үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэгч, хөрөнгө оруулагч, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчид нэгэн дор цуглардаг "BARILGA EXPO 38" дахь удаагийн барилгын үзэсгэлэн яармагт МБҮА ТББ нь Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн шинэ суурь нөхцөл, шаардлага болоод 2025.09.05-ны өдрөөс Зөвшөөрлийн нэгдсэн систем license.mn цахим системээр авдаг болсон талаарх мэдээ мэдээллийг өгч ажиллаж байна. Мөн МБҮА ТББ-ын үндсэн чиглэл болох Гишүүдэд чиглэсэн арга хэмжээ, Дулаан шийдэл төслийн талаар дэлгэрэнгүй мэдээ мэдээллийг өгч ажиллана.

МОНГОЛ, ХЯТАДЫН ФОРУМЫН БЭЛТГЭЛ АЖЛЫН ХҮРЭЭНД:

"Монгол–Хятадын Барилга, Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтын Форум" зохион байгуулах ажилд СБТСХ оролцож, хөтөлбөр боловсруулах, эцэслэн тохирох хүртэлх бүхий л үе шатанд СБТСХ-ийн ажилтнууд тухай бүр саналаа өгч ажилласан.

Түүнчлэн ХББОСЯ, ЗТЯ, ЭЗХЯ, АҮЭБЯ, ХОХГ, Хилийн боомтын захиргаа, Нийслэлийн ЗДТГ, төслийн нэгжүүдэд албан бичиг илгээж, биечлэн уулзаж тохирох, урилга хүргэж, МБҮА ТББ-ын Ерөнхийлөгчийн хэлэх үг, ГЗ-ын танилцуулах илтгэлийг монгол, англи хэлээр бэлтгэлээ. Мөн ХББОС-ын сайдын хэлэх үгийн төслийг бэлтгэн хүргүүлж, яам, Хөрөнгө оруулалт, худалдааны газраас тавих илтгэлийн сэдэв, агуулгыг ярилцаж тохирон илтгэлийг бэлтгүүлэн танилцуулах ажлыг хариуцан зохион байгуулав.

Үр дүн: Арга хэмжээг амжилттай зохион байгуулах, хоёр байгууллагын болон тэдгээрийн гишүүдийн хамтын ажиллагаанд шинэ алхамыг бий болгоход чухал хувь нэмэр оруулллаа.

САЛБАРЫН БОДЛОГО, СУДАЛГААНЫ ХҮРЭЭНД:

- Барилгын ерөнхий хууль, Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслүүдийн шинэчлэгдсэн ажлын хэсэгт орж, зарласан хуралд оролцож хэлэлцэж байгаа асуудлаар саналаа хүргүүлж ажиллалаа.
- Хамтран ажиллах санамж бичгийг хэрэгжүүлэх хүрээнд Нийслэлийн засаг даргын Тамгын газартай идэвхтэй хамтран ажиллаж, Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендер шалгаруулалтуудад өөрчлөлт оруулж, тендэрийг хуваан зарлаж дотоодын барилгын компаниуд оролцох боломжийг хангахад ажилласан.

Үр дүн: МБҮА ТББ нь гишүүдийнхээ дуу хоолой болж хууль, төрийн бодлого, шийдвэрт санал бодлыг нь хүргэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулллаа.

- "Барилгын салбарын 99 жилийн ой"-д зориулан "Их барилга-99" судалгааг бэлтгэн цахим брошур

хэлбэрээр, “Амьдралыг чанарыг хангахад барилгын салбарын үзүүлэх эерэг нөлөө” судалгааг бэлтгэн, цахим ном хэлбэрээр болон видео контент бэлтгэн нийтэд хүргэлээ.

Үр дүн: Гишүүн байгууллагуудыг албан ёсны тоон мэдээллээр хангахад чухал ажил болсон.

- Барилгын компаниудын чадавхыг үнэлэх, эрэмбэлэх судалгааны чиглэлээр SICA ХХК-тай хамтран ажиллах гэрээний төсөлд санал бэлтгэн хүргүүлж, SICA ХХК-тай хийсэн сүүлийн уулзалтаар ярилцсаны дагуу шилдэгт орох боломжтой 200 компанийн мэдээллийг авахаар Барилгын хөгжлийн төв рүү албан бичиг илгээсэн.

Мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн үйл ажиллагаа одоогоор идэвхтэй бус байгаа боловч тус ажлын хэсэг ажиллаж эхлэхэд дэмжин ажиллахэд бэлэн байна.

Үр дүн: Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах Төрийн болон бусад байгууллагуудтай хамтарч ажиллах “САНАМЖ БИЧИГ”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах Гишүүн байгууллагуудыг албан ёсны тоон мэдээллээр хангахад чухал ажил болсон.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Барилгын тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг license.mn системд буюу E-mongolia-д 2025.09.05-ны өдрөөс шилжүүлж байгаа бөгөөд ингэснээр тусгай зөвшөөрөл авахад дунджаар 21 хоног зарцуулдаг байсан бол 3 хоногт багтаан тусгай зөвшөөрлийг авах боломжууд бүрдэж байна.

2025.09.04 -ны өдрөөр БҮАТЗ хүсэгч ААНБ нь mcis.gov.mn хүсэлт явуулах хүсэлтийн эрхийг хаасан бөгөөд зөвшөөрлийн нэгдсэн систем license.mn цахим системээр 2025.09.05-ны өдрөөс авдаг болсон.

Та бүхэн доорх гарын авлага ашиглан зааврын дагуу хүсэлт гарган цахим гэрээгээ баталгуулжуулах боломжтой төдийгүй онлайн QR code бүхий цахим тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгогддог болоод байна.

https://online.anyflip.com/frhxh/bjds/mobile/index.html

БҮАТЗХ-ИЙН “НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”-ИЙН ТОЙМ

БҮАТЗ-ийн хэлтэс нь “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан 950 гаруй хуулийн этгээд, иргэдийг тухай бүр нь мэдээллээр ханган ажиллав.



БҮАТЗ-тэй холбоотой “Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд тавих нөхцөл, шаардлагын дагуу барилгын тусгай зөвшөөрлийг mcis.gov.mn-ээр хүссэн **65**-н хуулийн этгээдийн хүсэлт, материалыг баталгаажуулж, ХБББОСЯ-нд 2025.09.04-ны өдөр цахимаар илгээв.

ХБББОССайдын 2025 оны 124 дүгээр тушаалын дагуу “Зөвшөөрлийн цахим систем”-д шилжих ажлыг зохион байгуулан 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн “LICENSE.MN”-ээр хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж эхэлсэн.

Тус тайлант хугацаанд license.mn-ээр хүсэлт гаргасан БУ:57, ЗТ:18, ӨБ:3 нийт **78**-н хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулан ажиллав.



Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор mcis.gov.mn-ээр хүсэлт гаргасан **141** хуулийн этгээдийн хүсэлт хянагдаж, **1** удаагийн БАТАЛГААЖУУЛАЛТ-аар **65** хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулав. Үүнээс: Сунгалтаар **3**, Нэмэлтээр **13**, Шинээр **48**, Дахин олгохоор **1** хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулав. Сунгалтаар 3 хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга үгсралтаар 3. Нэмэлтээр 13 хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга үгсралтаар 10, Зураг төсөл боловсруулалтаар 3. Шинээр 48 хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга үгсралтаар 41, Зураг төсөл боловсруулалтаар 7. Дахин олгохоор барилга үгсралтын 1 хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулав. Эдгээр 1 удаагийн баталгаажуулалтаар давхардсан тоогоор 76 хуулийн этгээдийн материалыг шаардлага хангаагүйн улмаас буцаасан. Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, үгсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад тавих нөхцөл, шаардлагын дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн 65 хуулийн этгээдийн хүсэлтийн материалыг хянаж **263** инженер, техникийн ажилтнуудын бүртгэлд хяналт тавив. Мөн Зөвшөөрлийн цахим систем license.mn-ээр 173-н хүсэлт ирсэнээс 78 хүсэлт баталгаажиж, 51 хүсэлт буцаагдаж, 57 хүсэлт хянагдаж, 25 хүсэлт хянагдахаар хүлээгдэж байна.

- БҮАТЗ-ийг эзэмшигч хуулийн этгээдийн мэдээллийг холбогдох хууль тогтоомж болон ХББОССайдын 1 удаагийн тушаалын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын opendata.burtgel.gov.mn-д БУ: 5227, ЗТ: 1029, ӨБ: 187 хуулийн этгээдийн нийт **6443** мэдээллийг нээлттэй байршуулах хүсэлтийг хүргүүлэв.
- БҮАТЗ-тэй хуулийн этгээдийн мэдээллийн санд “Холбогдох бичиг баримт хэсэг”-т БУ: 4603, ЗТ: 932, ӨБ: 166 нийт **5701** хуулийн этгээдийн мэдээллийг үүсгэн www.mcis.gov.mn-ын нээлттэй байршуулав.
- Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яам (ЦХХХЯ)-ны тусгай зөвшөөрлийн цахим системд тайлант хугацаанд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын тушаалаар гарсан БУ: 204, ЗТ: 35, ӨБ: 4 нийт 243-н хуулийн этгээдийн мэдээллийг хүргүүлсэн.
- ХББОССайдын тушаалаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авч, гэрээ байгуулах тухай нийт **172** хуулийн этгээдэд масс мессежээр мэдээлэл хүргүүлэв.
- Зөвшөөрлийн нэгдсэн систем /https://license.mn//-д шилжихтэй холбоотой гарсан 45 алдааг мэдээллэж засварлуулсан. Бодит орчинд 21-н хуулийн этгээдийн туршилтыг БУ, ӨБ, ЗТ-ын ажлын хүрээнд хийж гүйцэтгэв. Хүсэлт гаргах бүх хэрэглэгчид зориулан 2 системд бүртгүүлэх гарын авлагыг бэлтгэн License.mn, mnca.mn, mcis.gov.mn, facebook.com/mnca фэйж хуудсанд байршуулаад байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг шинээр болон нэмэлт ажлын төрлөөр олгох, сунгах тухай 2025 оны 196, 197, 212, 214 дугаар нийт 4-н тушаалыг үндэслэн тайлант хугацаанд БУ:204, ЗТ:35, ӨБ:4 нийт **243**-н ширхэг үнэт цаасанд бичилтийг хийж, баталгаажуулав.

ДУЛААН ШИЙДЭЛ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД:

НОГООН БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН АРГА ХЭМЖЭЭНД ТӨСЛИЙН ДУЛААЛГЫН ЗӨВЛӨХҮҮДИЙГ ОРОЛЦУУЛАВ



Төрийн банкнаас “Тогтвортой өсөлт, хамтын түншлэл” арга хэмжээг энэ сарын 4-нд зохион байгууллаа. Арга хэмжээнд хүрээлэн буй орчинд эерэг өөрчлөлт авчрах ногоон бэлтгэн нийлүүлэгчид буюу 100 гаруй компани, барилгын салбарын бизнес эрхлэгчид нэгэн дор цуглаж, хамтын ажиллагааны шинэ боломжуудын талаар санал солилцлоо. Тус арга хэмжээнд төсөлтэй хамтран ажилладаг барилгын салбарын бизнес эрхлэгчдээс 5 дулаалгын зөвлөхийг урилгаар оролцуулав. Тус банкны зүгээс тогтвортой хөгжлийг дэмжих бодлого, үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээгээ бизнес эрхлэгчдэд танилцуулсан байна. Арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг доорх холбоосоор аваарай.

- https://www.facebook.com/share/v/1A9DHS4hJs/
- https://www.facebook.com/share/v/17UZgwrM7B/
- https://www.facebook.com/share/v/1B9c91ZSvJ/

БАРИЛГЫН ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТ, ДУЛААЛГЫН АЧ ХОЛБОГДЛЫН ТАЛААР 1000 ГАРУЙ ИРГЭНД МЭДЭЭЛЭЛ ӨГЛӨӨ



Арга хэмжээний нэр: “Барилга экспо38” Олон улсын үзэсгэлэн, худалдаа

Зорилго: Олон нийтэд барилгын эрчим хүч хэмнэлт, дулаалгын ач холбогдлын талаар мэдээлэл, ойлголт өгөх, төсөлтэй хамтран ажилладаг барилгын салбарын бизнес эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих, бригад /компанийхаа үйл ажиллагааг сурталчлан таниулах боломжоор хангах

Хэзээ: 2025.09.12-09.14

Хаана: Буянт-Ухаа Спорт ордон

Мэдээлэл авсан иргэдийн тоо: 1153

Үйл ажиллагаагаа сурталчилсан бизнес эрхлэгчийн тоо: 14

ДАРХАН-УУЛ АЙМАГТ БОЛСОН ТӨСЛИЙН ХӨНДЛӨНГИЙН ЗӨВЛӨХ ХОРООНЫ ХУРАЛД ОРОЛЦОЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ТАНИЛЦУУЛАВ

Европын Холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл II” Төслийн Хөндлөнгийн Зөвлөх Хорооны хурал 2025 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр Дархан-Уул аймагт зохион байгуулагдлаа.







Хуралд Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар, Дархан дахин төлөвлөлт ОНӨААТҮГ тэргүүтэй орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон төслийн хэрэгжүүлэгчид, банк санхүү, төсөлд хамрагдсан барилгын салбарын бизнес эрхлэгчдийн төлөөлөл зэрэг талууд оролцсон. Тус хуралд МБҮА ТББ-ын Дулаан шийдэл төслийн нэгжээс 2024 оны 10 дугаар сараас хойш хийж хэрэгжүүлсэн ажил, цаашдын төлөвлөгөөгөө Төслийн менежер Г.Мөнхтуяа танилцуулсан. Өнгөрсөн хугацаанд тус аймагт 2 удаагийн чадавхжуулах багц сургалт зохион байгуулж, 27 дулаалгын зөвлөх бэлтгэн, эдгээр барилгын салбарын бизнес эрхлэгчдийг 100 орчим өрхийн хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх хэмжилт, үнэлгээ хийх ажилд зуучилж, нэмэлт орлого олох боломжоор хангав. Мөн хурлын үеэр МБҮА ТББ-ын төслийн багийн боловсруулсан гарын авлагыг оролцогчдод хүргүүлэв. Дэлгэрэнгүй танилцуулгыг зургаар харууллаа.









"ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ ХАЛААЛТЫН СИСТЕМ БА СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСВЭРҮҮД" АХИСАН ШАТНЫ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ



МБҮА ТББ-ын хамтран хэрэгжүүлдэг "Дулаан шийдэл II" төсөл нь барилгын салбарын ААНБ, бизнес эрхлэгчдийг чадавхжуулах багц хөтөлбөрийн хүрээнд ***"Эрчим хүчний хэмнэлттэй халаалтын систем ба сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд" ахисан шатны*** сургалтыг 2025.09.25-нд зохион байгуулав. Сургалтыг ШУТИС-ийн дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төвийн захирал Б.Мөнхбаяр удирдан явуулсан. Оролцогчдыг сургалтын материалаар хангасан болно.

Сургалтын зорилго: Тогтвортой барилга ба барилгын эрчим хүч хэмнэлт, түлш болон зуухны төрлүүд, эрчим хүчний хэмнэлттэй халаалтын систем, дулааны насосын төрөл, ажиллах зарчим, нарны зайн систем төлөвлөлтийн талаар мэдлэг, мэдээлэл өгөх

Сургалтад хамрагдсан бизнес эрхлэгчдийн тоо: 17

МБҮА ТББ-ын гишүүн байгууллагуудын хамрагдсан байдал: Дабль пирамид констракшн ХХК, Инвескори Проперти ХХК, Сэрүүн ХХК

“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН БАГИЙН 2025.09-Р САРЫН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОЙМ

Д/д	Үйл ажиллагаа	Тоон үзүүлэлт
1.	Барилгын салбарын БЖДБЭ-дэд зуучилсан техникийн үнэлгээний захиалга	42
2.	Техникийн үнэлгээний захиалгыг хуваарилсан барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	17
3.	Барилгын салбарын БЖДБЭ-ийн хийж гүйцэтгэсэн техникийн үнэлгээний тоо	21
4.	Барилгын салбарын БЖДБЭ-дэд зориулан зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	4
5.	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд оролцсон барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	36
6.	Арга зүйн зөвлөмжийг өгсөн барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	17
7.	Санал, хүсэлт, гомдлыг нь шийдвэрлэсэн айл өрхийн тоо	12



МБУА
МОНГОЛЫН БАРИЛГЫН УНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Монгол Улс, Улаанбаатар 15141,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn